

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГАТАЙ 2024 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ АГЕНТЛАГИЙН ДАРГЫН ХҮЛЭЭХ ҮҮРГИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 06 сарын 13

Мандалговь хот

№	АГЕНТЛАГИЙН ДАРГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ	ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ
1	2	3	4
1	Засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр, Монгол улсыг болон аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, салбарын болон аймгийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын зорилт, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан бүрэн хэрэгжүүлж ажиллана	<ol style="list-style-type: none"> <li>1. АЗДҮАХ-т 1 зорилт, 4 арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг 100 хувь ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</li> <li>2. Стратегийн төлөвлөгөөнд 1 зорилт 3 арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилтийг 100 хувь ханган, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</li> </ol>	100
2	Улсын болон орон нутгийн төсвийн орлогыг цаг хугацаанд нь татварын орлогын нэр төрлөөр бүрэн төвлөрүүлнэ.	<p>2024 оны эхний 5 сарын байдлаар төсвийн орлого 8249637.9 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 12482041.8 мянган төгрөг төвлөрүүлж 151 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Үүнээс:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын төсвийн орлого 1663260.9 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 2428201.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 146 хувийн гүйцэтгэлтэй байна.</li> <li>2. Аймгийн төсвийн орлого 487360.0 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 3125531.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 641 хувийн гүйцэтгэлтэй байна.</li> <li>3. Сумын төсвийн орлого 6099017.0 мянган төгрөгийн төлөвлөгөө биелүүлэхээс 6928308.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 114 хувийн гүйцэтгэлтэй байна.</li> </ol>	100
3	Гадаадыг хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр санхүүжүүлэгч байгууллагуудад нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлнэ.	Төсөл бичээгүй. Албаны хэмжээнд 2 төрлийн төслийн санаа гарч төслийг бичиж байна.	50
4	Тухайн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсыг идвэхижүүлэх, аймаг орон нутгийн мэдээллийг тогтмол оруулж хэвших	Дундговь аймгийн Татварын газар пэйж хуудсаар дамжуулан 936 пост мэдээлэл байршуулан нийт 20335 иргэн үзсэн.	100
5	Нээлттэй Дундговь хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	``Бүсчилсэн хөгжил``Монголын эдийн засгийн форумд газрын дарга аймгийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж 2 өдрийн сургалт семинарт хамрагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хүрээнд цахим шилжилтийг Үндэсний хэмжээнд эрчимжүүлэх зорилгоор "Цахимд хэвшье" уриатай "Цахим хөгжлийн	100

		өдөрлөг” арга хэмжээнд тус хэлтсээс жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувиараа бизнес эрхлэгч, худалдаа үйлчилгээ үзүүлж буй ААН, иргэдэд дэлгүүрийн Цахим төлбөрийн баримтын систем, ПОС-н систем, гар утасны аппликейшн, санхүүгийн тайлан гаргах цогц программ хангамжийн талаарх танилцуулга арга хэмжээнд хамтран ажиллалаа.	
6	2024 оныг аймгийн засаг даргын захирамжаар “Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан ажлын төлөвлөгөө боловсруулж үр дүнг тооцон ажиллах	Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын жилийн төлөвлөгөөг 2 зорилт, 19 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж хэрэгжилийг ханган ажиллаж эхний хагас жилийн хэрэгжилтийг гаргаж холбогдох албан хаагчид хүргүүлсэн.	100
7	Хүүхэд хамгааллын хүрээнд болзошгүй эрсдэлээс хамгаалсан аюулыг илрүүлэх, арилгах талаар санал санаачлага гарган ажиллах	Албаны ойр орчимд 1 эрсдэл бүхий газрыг илрүүлэн холбогдох байгууллагад мэдээлэл хүргүүлсэн.	70
8	Аймгийн засаг даргын 02 дугаар захирамжаар “Үндэсний дээл хувцасаа өмсөж хэвших уриалгыг” хэрэгжүүлж соёлыг дэлгэрүүлэх	Сар бүрийн 3 дахь долоо хоногийн Лхагва гарагт 5 удаа албан хаагчид үндэсний хувцас өмсөж хэвшсэн бөгөөд албаны пэйж хуудас, вэб сайтаар дамжуулан уриалгыг гаргаж хэвшсэн.	100
9	Хог хаягдлаа ангилан ялгах, хоёрдогч түүхий эд авах цэгүүдэд нийлүүлэх	Хог хаягдлыг ангилан ялгах сав хийлгэж байршуулсан. Албан хаагчдаас хуванцар сав цуглуулдаг.	80
10	Тэр бус мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчлах, ургуулах ажлыг зохион байгуулах	Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран төв зам дагуу 250 мод, албаны гадаа 60 мод нөхөн тарилт, Удирдлагын академийн төгөлд 5 мод тарьж долоо хоног бүрийн даваа, пүрэв гарагт услаж хамгаалалтын хүрээ хийсэн.	100
11	Дундговь ногооруулья хөтөлбөрийн хүрээнд байгууллага бүр хүлэмжний ногоо тариалах, сургалтад албан хаагчдыг хамруулах	Дундговь аймгийн засаг даргын тамгын газар, Байгаль орчин аялал жуулчны газраас зохион байгуулсан сургалтад татварын улсын байцаагч А.Ганзаяа хамрагдаж албан хаагчдад нарийн ногооны үрсэлгээг хэрхэн хийх талаар 1 удаа сургалт зохион байгуулж албан хаагч бүр салатны навч үрслүүлж ургууллаа.	100
12	Төрийн байгууллага бүр албан хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг турших	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжилтийн хүрээнд баталсан “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага”-ын дагуу 2024 оны 02 сарын 16-нд байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх хэвлэмэл хуудсыг стандартын дагуу хийлгэн Аймгийн архивын тасагт хүргүүлэн хянуулж зөвшөөрөл авсан. Газрын даргын албан тоот, тушаал зэргийг хос бичгээр хэвлэж туршсан.	100

13	Удирдах, удирдуулах зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод нээлттэй, авилгагүй шударга, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, хүнд суртлыг арилгах арга хэмжээг авч ажиллах	<ol style="list-style-type: none"> <li>1. Албан хаагчдад ёсзүйн сургалтыг 1 удаа, төрийн албаны зөвлөлийн ёсзүйн цахим сургалтад 2 хамруулан ажилласан.</li> <li>2. Цаг үеийн нөхцөлөөс хамаарч жилийн эцсийн татварын тайлан илгээх, хүлээн авах, иргэдийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайлан илгээх хугацаанд 1, 2 сард цайны цаггүй үйлчилгээг нэвтрүүлэн ажилласан.</li> </ol>	100
14	“Цахим байгууллага” аяны хэрэгжилтийг хангаж ажиллах	<ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн байгууллагын зарлагын гүйлгээ нэхэмжлэхэд суурилсан болгож цахимжсан нь албан ажлын үр дүнд маш сайнаар нөлөөлсөн.</li> <li>2. Төрийн албаны ХУРДАН системийг байгууллага дээрээ суурьлуулан, и монголиагийн баг ажилчид ирэн ажиллаж шинэчлэлийг 1 удаа хийсэн.</li> <li>3. Татвар хураах ПОС төхөөрөмжийг 11 сум авч ашиглаж байна. Энэ нь иргэдийн цаг хугацааг хэмнэн, банкины дараалалд зогсолгүй цахимаар татвар төлөх боломжийг нээсэн. Мөн иргэн бүх төрлийг татварыг аль ч банкны интернет ашиглан төлөх боломжтой юм.</li> <li>4. Татварын тайлан, хүсэлт, бүртгэл, нууц үг солих, төлөлт зэрэг бүх төрлийн үйлчилгээг etax.mta.mn, ebarimt.mn сайтыг ашиглан авах боломжтой</li> </ol>	100
15	Аймгийн засаг даргаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай, чанартай зохион байгуулж ажиллана.	Аймгийн засаг даргын тамгын газраас 63 албан бичиг ирж үүнээс 23 нь хугацаатай үүрэг даалгаварыг тухайн хугацаанд нь гүйцэтгэж ажилласан.	100
<b>ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ</b>			<b>93</b>

ХЯНАСАН:  
ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА                      М.ТУЯАЦЭЦЭГ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:  
ТАСГИЙН ДАРГА                                  Ш.МӨНГӨНЦЭЦЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

.....ажилтай.....